

«ЭЛЧ» МЭДЭЭ БА ТҮҮНИЙ  
УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Л.Норовсүрэн\*

\* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн профессор

**Түлхүүр үг:** мэдээ занги, элч довтолгох, дуун бариулах, дохио зангаа, гэрэгэ, шувууны өд, морины туурай, нис нис, элчин харилцаа, дипломат ёс.

**М**онголын ард түмэн эрт дээр үеэс мэдээ занги солилцох баялаг уламжлалтай бөгөөд тэр нь соёл, түүхийн чухал эх сурвалж болж, бас ч орчин үеийн нийтлэл хийгээд сэтгүүл зүйн туурвилд үнэт туршлага, сургамж болсоор ирсэн билээ. Орчин үеийн мэдээлэл харилцааны хөгжил нь эртний хүмүүсийн мэдээ занги солилцох эгэл хэлбэрүүдээс эхтэй юм. Мэдээллийн харилцаа нь хэдийгээр эгэл болхи ч гэсэн монгол газарт хүн аж төрөх болсон үе буюу ойролцоогоор 750 орчим мянган жилийн тэртээгээс үүссэн байна.

Монголчуудын хувьд хүн төрөлхтний харилцааны хамгийн анхны нийтлэг хэлбэр болох дохио зангаанаас эхлээд эд юмс, сүг зураг, им тамга,

аман яриа, элч довтолгох зэрэг мэдээллийн харилцааны олон аргыг хэрэглэж ирсэн байдаг. Түүний дотроос өнөөг хүртэл уламжлагдан, хүрээ далайц нь тэлж, нэг улс аймгаар зогсохгүй дэлхий нийтийн харилцааны шалгарсан арга болсноороо элч мэдээ онцгой содон юм.

Эрт цагт алс газарт мэдээ занги дамжуулах бараг цорын ганц хэрэгсэл нь хүн өөрөө байсан гэж хэлж болно. Эд юмсаар харилцдаг байх цагаас эхлээд бичиг захидал илгээх болсон үед ч хүн л түүнийг хүргэдэг байсан аж. Хүнээр мэдээ занги хүргүлэх нь хоёр янз байсан бололтой. Нэг нь ямар нэг эд юмс, эсвэл захидлыг зохих эзэнд нь хүргэж өгөх, нөгөө нь хүн өөрөө мэдээ болох явдал мөн. Бүр хожуу үед буюу үсэг бичигтэй болсны дараа ч элч мэдээ чухал үүрэгтэй байжээ. Ялангуяа дайн самуунтай, цаг төр тайван бус нөхцөлд элч мэдээг илүү найдвартай гэж үздэг байсан бөгөөд замд олзлогдоход хүрвэл бичиг захиа, бусад

эд мөрийн баримт олдохгүй, хэл мэдээ зөвхөн элчтэй хамт устдаг байжээ.

Ийнхүү элчээр мэдээ дамжуулахыг монголчууд «Дуун бариулах» гэдэг байв. Энэ нь мэдээ чимээ зөвхөн элчийн дуу хоолойгоор дамжих учрыг илтгэх бөгөөд хүргэх мэдээнийхээ агуулгыг гүн утга, яруу сонсголон бүхий шүлгийн хэлбэрт оруулаад элчид ягштал цээжлүүлсний дараа илгээдэг байв. Үүнийг Чингис хаан Сэнгүм андад хэлүүлсэн үгэндээ: «"Би эцгийн дээлтэй төрсөн хөвүүн ажээ. Чи нүцгэн төрсөн хөвүүн ажээ. Хан эцэг бид хоёрыг нэгэн адил асардаг. Үүнд Сэнгүм чи атаархан завсардуулж намайг хөөлгөв. Одоо чи, хан эцгийн элгийг эмгэнүүлэхгүй, зүрхийг зүдүүлэхгүй, өглөө үдэш орж гарч санааг баясган, сэтгэлийг сэргээж яв. Чи эртний санаснаа үл тавин, хан эцгийг амьд байталхан болох гэж эцгийн сэтгэлийг битгий зовоо" гэж Архай Хасар, Сүхэхай жэун хоёрт энэ үгсийг цээжлүүлж илгээв» («Монголын нууц товчоо» 181-р зүйл) гэсэн мэдээ болон бусад олон баримтаас тодорхой мэдэж болно. Элч нь эзэндээ үнэнч, ямар ч үед нууц задруулахааргүй

найдвартай хүмүүс байдаг байсан нь мэдээжийн хэрэг. Энэ тухай эртний Сүн улсын цэргийн жанжин Хун мин гэгч XIII зууны хориод оны үед Монгол газарт зорчсон тухай тэмдэглэлдээ «Эзэн нь ямар нэг тушаал буулгах, гэрээ хэлцэл хийхдээ зөвхөн элч илгээдэг.

Харин илгээсэн зүйлээ мартахгүйн тулд болхи тэмдэглэгээ хийдэг байв.

«

*Эрт цагт алс газарт мэдээ занги дамжуулах бараг цорын ганц хэрэгсэл нь хүн байжээ. Эд юмсаар харилцдаг байх цагаас эхлээд бичиг захидал илгээх болсон үед ч хүн л түүнийг хүргэдэг байсан аж.*

*Хүнээр мэдээ занги хүргүүлэх нь хоёр янз байв. Нэг нь ямар нэг эд юмс, эсвэл захидлыг зохих эзэнд нь хүргэж өгөх, нөгөө нь хүн өөрөө мэдээ болох явдал мөн. Бүр хожуу үед буюу үсэг бичигтэй болсны дараа ч элч мэдээ чухал үүрэгтэй байжээ.*

»

Монголчууд элчээр харилцах эртний уламжлалаа XIII зууны үеэс төр ёсны нарийн дэг жаягтай болгосон нь эртний харийн элч, жуулчдын тэмдэглэлд тодорхой туссан байдаг. «Монгол-татарын бүрэн тэмдэглэл»-д «Хааны зарсан элчийг тохиолдсон газар орны эрх баригчид цөмөөр хүндэтгэн өнгөрүүлэх, элчийн зэрэг дэвийн их, багыг харгалзахгүй алба хэрэг, танхимд хүндэт суудалд суулгах, хүндэт харуул гаргаж сахиулах, элчийг их хаалганы

Элч нь дамжуулсан үгийг ганц ч үгийн зөрөөгүй илтгэдэг бөгөөд энэ нь тэдний том уламжлал юм» гэсэн байдаг. Мөн Рашид-Ад-дин «Монголчууд эрт цагаас элчүүдэд голдуу толгой холбон шүлэглэсэн ёгт уран үгийг цээжээр хэлж дамжуулдаг заншилтай» гэж бичсэн бий.

гадна угтан уулзахдаа хэнгэрэг дэлдэн, хөгжим үүсгэж, хиур далбаа барьж жагсах» зэрэг зан үйлийг гүйцэтгэдэг байсан тухай өгүүлээд, харин «Элчийг хаанд бараалхахад төдий л их ёслол гүйцэтгэхгүй, маш шулуун үг өгүүлэх нь тэдний эртний эгэл ёс бөгөөд тэр, зан заншил нь эвдрээгүйн шинж тэмдэг» гэсэн байдаг. Монголчууд бас харийн элчдээс өөрийн ёс журмыг дагахыг шаарддаг, эс биелүүлбэл Их хаанд бараалхуулдаггүй байжээ. Ирсэн элчийг задгай галын дундуур оруулдаг байсан бөгөөд тэр нь галыг хамгийг ариутгагч гэж үздэгтэй холбоотой ажээ. Өрнө зүгийн нэг элч уг шаардлагыг дагаагүй учир Хаанд бараалхуулалгүй буцаасан байдаг.

Мөн Их хааны хөрөгт мөргүүлэх зан үйлийг гүйцэтгэдэг байв. Тийнхүү мөргөх нь Монголын Их хааныг чин сэтгэлээс хүндэтгэж байгаагийн илрэл болохын хамт ертөнцийг захирагч ганц эзэн нь Монголын Их хаан мөн гэдгийг хүлээн зөвшөөрүүлсэн агуулгатай байжээ. XIII зууны үеэс бичгээр харилцах харилцаа нэлээд түгээмэл болоход хятад зүгт харилцахыг хятадаар, баруун зүгт харилцахыг уйгаржин монгол бичгээр бичиж байсан ба хаан болон хааны төлөөний сайдад гадаадын элчин бараалхахад хэлмэрч хэрэглэдэг байв.

Бас гадаадын элчийг хүндэтгэн сархдаар дайлж, илдний наадам үзүүлж, идүүлж, уулгах зэргээр чин

сэтгэлээсээ ханддаг байсан байна. Үүнийг «Чи нэгэнт манай улсад ирсэн болохоор бидэнтэй нэгэн гэр бүлийн хүн болсон. Хэзээ нэг цагт найрлан цэнгэх, бөмбөг тоглох, буга гөрөөс агнах, амарч зугаалахаар явах тоолонд бидэнтэй хамт цэнгэхээр ирж байгтун гэв. Тэгээд Го-ван тачигнатал инээж баясах зуур элчинг зургаан хундага дарсаар торголоо. Орой тийшээ элчин учиргүй их согтож, найр өндөрлөлөө» гэж «Монгол-татарын бүрэн тэмдэглэл»-д бичсэн зүйл давхар нотолж байна.

**Т**эр үед элч нь монгол төрийн биет төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэдэг байсны улмаас зам зуурт найдвартай хамгаалуулах, бас өөрөө ёс журамтай, итгэл найдвартай байх үүрэг хүлээдэг байжээ. Элчид зөвхөн зурвас, пайз, ямар нэг таних тэмдэг өгч явуулдаг байсан нь өөрийн элч мөн болохыг батлах зорилготой байжээ. Энэ санаагаа бүр баримтжуулж «гэрэгэ» хэмээх алт, мөнгөн пайз өгч явуулдаг ёс ч байжээ. Хэрэв зурвас дагалдуулахад хүрвэл «Хэлэх үг элчийн аманд» гэсэн үг бичдэг байв.

Элч илгээж мэдээ занги авалцах нь Монголчуудын хувьд, ялангуяа төрийн чухал явдалд өргөн хэрэглэгддэг байсныг батлах баримт түүх шастирт элбэг үзэгддэг билээ. Лувсанданзаны «Алтан товч»-д «Чингис хааныг хаан болгов хэмээн Хэрэйдийн Тоорил хаанд Тахай, Сүгэй хоёр элчийг

илгээв» гэсэн мэдээ байх бөгөөд Тоорил хаан түүний хариуд:

«Эв эеэ бүү эвдэгтүн

Эе зангиа бүү тайлагтун .

Эх захаа бүү алдагтун» гэсэн захиасыг элчид хэлж илгээсэн гэж өгүүлдэг.

**М**эдээлэл харилцаа, шуудан тээвэр хөгжөөгүй байсан XIII зууны үед элч нь мэдээллийг өөрийн биеэр тээж, өөрийн үгээр дамжуулдаг нэг ёсны хэрэгслийн үүрэг гүйцэтгэдэг байв. Тиймээс ч эзэн Чингисийн «Их засаг» хуулинд элч төлөөлөгчийн аюулгүй байдлыг баталгаажуулж «Элч зарлагыг гутаан доромжилж үл болно» гэж заасан байдаг. Чингис хаан хуулийнхаа энэ заалтыг хэрэгжүүлэхийг эрхэм дээд үүрэг гэж үздэг байсан нь дайн дажинтай тэр цагт төрийн хэрэгт элчийн үүрэг асар их байсантай холботоой юм. Тиймээс ч Чингис хаан өөрийнх нь илгээсэн 400 гаруй хүний бүрэлдэхүүнтэй элчдийг хүйс тэмтэрсний хариуд Хорезм улсад дайн зарлаж, цээрлэл үзүүлсэн түүхтэй. Нөгөө талаар элч зарлага нь зөвхөн хэл мэдээ залгуулагч төдий бус Эзэн хаан болон төрийн төлөөлөгч, өнөөгийн жишгээр бол Элчин сайдтай эн зэрэгцэхүйц үүрэгтэй хүн байв. Тэр тусмаа «Таван өнгө, дөрвөн харь улсаас эхлэн Замбутивийн гурван зуун жаран нэгэн омогтон, долоон зуун хорин хэлтэн улсын алба гувчуур авч, гар газар, хөл хөсөр амаржуулж,

Заграварди хаан мэт алдаршсан» (Лу. Алтан товч. 20 дахь тал) Дэлхийн нэгдсэн улсын элч төлөөлөгчдийг бүрэлгэнэ гэдэг бол «Их засаг» хуулиа мөнх тэнгэрийн зарлиг гэж үздэг байсан Чингис хааны хувьд бүр ч тэсвэрлэшгүй доромжлол байсан учраас тийнхүү ариун дайнд мордож байжээ.

Эрдэмтэн зохиолч Л.Түдэв нэгэнтээ «Их Монголын эзэнт гүрний захидал харилцаа дамжуулагч гол хүн нь элч, элчин хэргэм зэрэгтэй "дуун бариулах" албатай байсныг «Монголын нууц товчоо»-нд дээрх хоёр үг хорь гучин удаа давтагддагаас гадна "дуун бариулах" зан үйл таван удаа давтагддагаас илэрхий болно. Түүнээс гадна "хэлэх үг элчийн аманд буй" гэдэгт итгэх аргагүй нэгэн тохиолдол бол тэр "Элч" гээд ирж байгаа хүн өөрөө жинхэнэ элч мөн үү, биш үү гэдэгт итгэхгүй гайхах зүй ёсны эргэлзээ юм. Түүнийг үгүй болгох зорилгоор төрийн элчин юм уу, цэргийн элч хүнд бас алт, мөнгө, модон гэрэгэ зүүлгэх юм уу, өвөртлүүлэн явуулдаг байжээ. Тийм гэрэгэ-г дээд талдаа зүүх, ганзгалах нүхтэй зууван булантай гонзгой пайз хэлбэртэй үйлдэж, алт, мөнгөн дээр "Мөнх тэнгэрийн хүчин дор, их суу залийн эрхэн дор, хааны зарлиг. Хэн үл бишрэх хүмүүн алдах, үхэх" гэсэн бичиг хөөмөлдөж төвийлгөн сийлж хийдэг байжээ» хэмээн тэмдэглэсэн байдаг.

Монголын их гүрний үед элчийг төрийн чухал алба залгуулагч хэмээн

үзэж, нэн хүндэтгэлтэй ханддаг байсны зэрэгцээ, бас хариуцлагыг өндөрт тавьдаг байжээ. XIII зууны үед Монголд ирж байсан Гильом де Рубрукийн тэмдэглэлд монголын хуулинд «Элч төлөөлөгч биш атлаа өөрийг элч төлөөлөгч гэж худал хэлсэн хүнийг алж шийтгэнэ» гэж заасан тухай өгүүлсэн байдаг. Энэ нь элчийн халдашгүй байдлыг хамгаалахын зэрэгцээ, түүний онцгой үүргийг дархлах санааны илрэл мөн байв.

Монголчуудын элчин харилцааны түүх тэртээх Хүннү гүрний үед нэлээд боловсронгуй төвшинд хүрсэн байжээ. Тэр үед элч төлөөлөгчийг ихэд хүндэтгэн, өөрийн улсыг гадаадад төлөөлөх бүрэн эрхт хүн хэмээн үзэж, үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүх эрхээр ханган, тэдний халдашгүй эрх дархыг дархлах “гэрэгэ” олгодог ёс тогтжээ. Үүнийг «Элч нь эзнийхээ өмнө, эзэн нь Шаньюй миний өмнө ёс алдсанаа хүлээх болно» хэмээн МЭӨ 209 онд Моадунь Шаньюй-гийн хэлж байсан үг батална. Хүннү гүрний үед гэрээг аман болон бичгийн хэлбэрээр байгуулдаг байв. Үүнд аман хэлбэр нь «Анд боллоцх», «Тангараг өргөх ёс» байв. Харин МЭӨ 198 онд Хан улс, Хүннү гүрний хооронд хоёр улсын хилийг Цагаан хэрмээр зааглах тухай санааг «Урт хотоос хойш нум барьсан улс Шаньюйн цаазыг дагатугай. Урт хотоос дотогш дээл; малгайн улсыг би захирсугай» хэмээн тогтсон нь Монголчуудаас харь улстай тогтоосон анхны

бичмэл гэрээ байжээ. МЭӨ 122 оны үеэс Хүннүгийн Шаньюйд бараалхах гадаадын элчийг урьдчилэн хүлээн авах «Зочин эрхэлсэн түшмэл»-тэй болсон нь дипломат ёсыг гүйцэтгэх тусгай байгууллагын эх суурь тавигдаж байсан хэрэг юм. Уг алба нь гадаад харилцааны хэв журам, дипломат ёсыг мөрдөх, харь улсын элчийг хүлээн авах, ёс заншил үйлдэх, гадаадад илгээх бичиг, гэрээ хэлэлцээрийн эхийг боловсруулж бэлтгэх, хадгалах үүрэгтэй байв.

**М**онголчуудын элчээр харилцах уламжлал Их Монгол гүрний үед эрс өсөн нэмэгдэж, тэр нь хоёр хүний харилцаа, төр, цэргийн хэргийн мэдээ сэлт дамжуулах хэрэгслийн хүрээнээс хальж, Монгол гүрнээс дэлхий дахинтай харилцах хэрэгсэл болсон байна. Үүнийг XIII зууны үед Монголын болон гадаадын элч төлөөлөгчдийн бичиж үлдээсэн тэмдэглэл хийгээд сурвалж бичгүүд тодорхой харуулдаг. Монголоос бусад улс гүрэнтэй элчээр харилцаж байсныг тусгасан олон ном зохиол байгаагийн дотор «Монголын нууц товчоо», Ираны түүхч Рашид-Ад-диний «Судрын чуулган», Оросын эрдэмтэн И.Бичурины Ган Му, Юань Ши-гээс түүвэрлэн орчуулсан «Чингисийн ургийн эхний дөрвөн хаадын түүх», XIII зууны үед Монголд ирсэн Плано Карпини, Гильом де Рубрук, Марко Поло нарын болон Монголын Ил хааны элчээр зарагдаж

Ромын Пап, Францын хаан, Английн ванд тус тус бараалхсан Бар Саумын тэмдэглэл, тэр үеийн эрдэмтэд, төрийн зүтгэлтнүүдийн туурвисан бичиг зохиолууд чухал мэдээллийг агуулдаг.

Түүнчилэн Монголд ирсэн гадаадын элчдийн тухай баримтын эмхтгэлийг орчуулж хэвлүүлсэн Д.Якыковын «Татар ба Дорно зүгийн бусад орнуудад жуулчилсны цоморлиг» хэмээх бүтээл, Ираны түүхэн сурвалжуудаас В.Тизенгаузенй түүвэрлэн эмхтгэсэн «Алтан ордны түүхэнд холбогдох материалын эмхтгэл» зохиолуудад элчийн харилцааны тухай их, бага хэмжээгээр дурдсан байна. Чингис хаан

болон түүнийг залгамжлагчид элчин харилцааг "төрийн алтан аргамж", гадаад бодлогын чухал хэсэг гэж үзэн, уг ажилд аль болох чадвартай хүмүүсийг ашиглахын зэрэгцээ, гадаад орнуудын хэл соёл, хэв заншил, ёс суртахуун, горим журмыг сайн мэддэг харийн хүмүүсийг дипломат харилцаанд ашиглахыг эрмэлздэг байжээ. Чингис хаан Елюй Чу Цай мэтийн эрдэмтэн, Марко Поло зэрэг харийн худалдаачдыг ашиглаж байсан нь санамсаргүй хэрэг биш ажээ. Өгөдэй

хааны үед өртөө замыг байгуулсны нэг зорилго нь элчин харилцааны зам чигийг тодорхой зааж, саадгүй түргэн нэвтрүүлэхэд чиглэгдэж байжээ.

XIII-XIV зууны үед Хүннү гүрний элчин харилцааны уламжлал улам гүнзгийрч "Төрийн хэрэг эрхлэх газар", "Нууц бичгийн яам", "Ёслол эрхэлсэн түшмэл" зэрэг байгууллага, хүмүүс монгол төрийн элчин харилцааг эрхлэх болжээ. Монголчуудын гадаад харилцаанд гэрээ хэлэлцээр байгуулах явдал чухал суурийг эзэлж байв. Гэрээ хэлэлцээр нь худалдааны, найрамдлын, цэрэг-улс төрийн гэх мэт олон янз байжээ. Гэрээ хэлэлцээр байгуу-

лахдаа тухайн үед олон улсын харилцаанд нийтээр баримталж байсан хэмжээ, ёс журмыг хатуу дагаж мөрдөхийн зэрэгцээ бичмэл гэрээний эхийг өөрсдөө уйгуржин монгол ба дөрвөлжин үсгээр, харилцагч талынхыг тухайн улсын хэлбичгээр хийж хааны тамга дардаг заншилтай байв.

Монголын нэгдсэн улсын үеэс элч нь харь оронд явж төр улсын хэргийг бүтээдэг мэргэжлийн хүний үйл ажиллагаа болсон бөгөөд, өөрийн гарал язгуур, гүйцэтгэх үүргээсээ хамаарсан

«

*Монголчуудын элчээр харилцах уламжлал Их Монгол гүрний үед эрс өсөн нэмэгдэж, тэр нь хоёр хүний харилцаа, төр, цэргийн хэргийн мэдээ сэлт дамжуулах хэрэгслийн хүрээнээс хальж, Монгол гүрнээс дэлхий дахинтай харилцах хэрэгсэл болсон байна. Үүнийг XIII зууны үед Монголын болон гадаадын элч төлөөлөгчдийн бичиж үлдээсэн тэмдэглэл хийгээд сурвалж бичгүүд тодорхой харуулдаг.*

»

тусгай зэрэг дэвтэй байжээ. Элчийг зөвхөн хааны зарлигаар томилдог учраас тэднийг ерөнхийд нь «Зарлигийн элч» гэдэг. Дотроо "Бүрэн эрхт элчин, "Төлөөний элч", "Элч", "Элч-худалдаачин" гэж ангилагддаг байв. Хаадын зарлиг, харь улсад илгээх албан бичигт «Мөнх тэнгэрийн хүчин дор» гэсэн үгийг заавал бичдэг, мөр тэтгэх, дарах ёсыг журамладаг байсны дээр гадаад харилцааны албан бичгийн эх зохиох, бичих тусгай хүн ажилладаг байжээ.

**М**онгол гүрний элчин харилцаа жилээс жилд өргөжиж, улмаар Өрнө зүгийн орнуудтай элч төлөөлөгч солилцон харилцах болжээ. Чингис хаан монгол олон аймгуудыг нэгтгэснийхээ дараа Хиргис, Уйгур улсуудтай харилцаж эхэлжээ. Энэ нь 1207 онд Алтан, Бура гэдэг хоёр элчийг тэдгээр улсуудад зарж явуулсны хариуд Хиргисийн ноёд цагаан шонхор, цагаан агт, хар булгаар бэлэг бариулан хариу элч илгээж байснаас тодорхой байна. Уйгур улсад 1209 онд Алп Унук, Дурбай нэрт хоёр элчийг илгээхэд Уйгурын Идүүд хаан хариуд нь элч илгээж «Тавдугаар хөвүүн чинь больё» хэмээн дагаж орох болсноо хэлүүлж байжээ.

Үүний дараа Алтан улс, Өмнөд Сүн, Солонгос, Тангад, Сартуул зэрэгтэй элч ээр харилцсан байдаг. Алтан улс тай харилцсан нь тэдний хараат байдлаас гарах, улмаар байлдан дагуулах зорилготой байсан бол, өмнөд

Сүн улстай найрсаг харилцааны журмаар харилцаж байв. 1214 онд Сүн улсад анхны элчийг илгээсэн боловч замд нь Алтан улс саад хийсэн тул 1220 оноос өргөн харилцаа тогтоож эхэлсэн байна. Сүн улсын элч 1221 онд Бээжинд ирж Монголын хааны төлөөний сайд Мухулайтай уулзан хэлэлцээ хийсэн бол, үүний дараахан Монголын элч Зобхан Сүн улсад очиж байжээ. Энэ тухай «Монгол-Татарын бүрэн тэмдэглэл»-д «Монголчууд ойрын жил манай Сүн улстай гэрээ хэмжээ тогтоох тухайд хоёрдугаар элчин Цагаан Татарын Собохан байсан ажгуу. Харилцах цагт Собахан хэзээ ч аягүй үг хэлсэнгүй. Харин төлөв зантай, анхаарамтгай, хөдлөх бүр ачийг хариулан, юу ч хайрлахгүй байсан амуй» хэмээн бичсэн байдаг.

1218 онд Хятаны үлдэгдлийг хөөж цохих нэрийдлээр монгол цэрэг Солонгост цөмөрсөн цагаас монгол элч нар Солонгост байнга очих болжээ. Харин Тангад улстай 1200 оны орчмоос харилцаж ирсэн бөгөөд харилцаандаа элч төлөөлөгч илгээх, цэрэглэн довтолох зэргээр «үгээр үхүүлж, сүрээр дайлайлгах» аргыг түлхүү хэрэглэж байв.

Хорезмын Шах 1215 онд Чингис хаан Хятадыг эзэлсэн нь үнэн эсэх хийгээд түүний цэргийн хүчийг тандах зорилгоор Ходжендийн Ахмед, Хусейн ноёны хүү Ахмед Балчич нараар толгойлуулсан элчдийг Монголд илгээсэн байна. Чингис хаан тэдгээр элчийг

дуртай хүлээн авч удалгүй худалдааны гэрээ байгуулсан байдаг. Дээрх элч төлөөлөгчдийн хариуд Чингис хаан элч илгээж найрамдалтай байх, худалдаа наймааны аюулгүй байдлыг хангах, бие биедээ харилцан зочлох санаагаа илтгэжээ. Монгол гүрний элчин харилцаа цаашид өргөжиж хойт Иран, Кавказын орнууд, Кипчак, улмаар Оросын вангуудтай харилцах болжээ. Орос, Монголын хооронд 1223 онд анхны элч солилцсон байдаг. Өмнөд Оросын нөлөө бүхий вангууд цуглаж Татарын эсрэг хамтран тэмцэх асуудлыг хэлэлцэх үеийг нь тааруулан Зэв, Сүвгэдэй нарын элч Киевт анх очсон байна. Тэдгээр элч «Бид та нарын газар, хот сууринд халдахгүй, гагцхүү пловцуудыг мөрдөж явна. Та нар бидэнтэй найрамд» гэж шаардахад Оросын вангууд зөвшөөрөөгүйгээр барахгүй элчийг алж, зэвсэглэн хөдөлсөн түүхтэй.

Монголын Эзэнт гүрэн мөхсөний дараа ч гэсэн элчин харилцааны уламжлал хадгалагдсаар байв. Энэ үед бурханы шашин дэлгэрсэнтэй холбоотойгоор элчийг хаанд бараалхуулах үеэр бурханд мөргүүлэх дэг ёс тогтсон байдаг. Монголчууд Манжийн эрхшээлд байсан үед мартагдах шахаад байсан дипломат ёс Богд хаант Монгол улсын үед дахин сэргэжээ. Тэр үед төрийн дипломат ёсыг дипломат харилцаа, дипломат ёслол гэсэн хоёр хэсэгт ангилж үздэг байсан бөгөөд энэ ажлыг эрхлэх "Гадаад хэргийн яам"

байгуулсан байна. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараа ч өмнөх уламжлалаа залгаж "Гадаад явдлын яам" байгуулж, гадаад бодлогын чиг шугамыг боловсруулах, дэлхий нийттэй харилцах, гэрээ хэлэлцээр байгуулах, элчин, төлөөлөгчдийг угтан авах, үдэж мордуулах, хүндэтгэл үзүүлэх зэрэг олон үүргийг хариуцуулах болсон билээ.

**Д**ээр дурдсанаас үзэхэд монголчуудын элч мэдээ өнөө үед хүртэл уламжлан хөгжиж ирсэн байдлыг гурван үе шатанд ангилж болохоор байна. Үүнд: нэгдүгээрт: элч довтолгох нь эхэн үедээ хоорондоо хол зайтай байгаа хүмүүс мэдээ занги солилцох энгийн арга байсан, хоёрдугаарт: түүний цаашдын хөгжил нь нэг улс аймгийн хэмжээнээс хальж, төр гүрнүүдийн хоорондын харилцааны чухал хэрэгсэл болсон төдийгүй, элч нь зөвхөн мэдээ хүргэгч төдий бус, улс орноо төлөөлөх төрийн төлөөлөгчийн онцгой үүрэг гүйцэтгэх болсон, гуравдугаарт: орчин үед элч нь илгээгдсэн улс орондоо байнга сууж дипломат харилцааг залгуулж байх онц бөгөөд бүрэн эрхтэй элчин сайд болж шинэчлэгдсэн байна.

Орчин үеийн олон улсын харилцааны шилэгдмэл арга болсон дипломат үйл ажиллагаа нь эртний хүмүүсийн хооронд мэдээ занги солилцох эгэл хэлбэр буюу "элч мэдээ" илгээх, "элч довтолгох" зан үйлээс эхтэй ажээ.



### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Бор Ж. 1994. Билгүүн дипломат чингис. УБ.
2. Бор Ж. 1998. Монголын дипломат товчоон. УБ.
3. Жувейни А. 1999. Монголын соёлын түүх. УБ.
4. 1999. Монгол улсын түүх. УБ.
5. 1975. Монголын нууц товчоон. УБ.
6. 1992. Монголын түүхийн дээж бичиг. Тэргүүн дэвтэр. УБ.
7. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ.
8. Поло М. 1987. Орчлонгийн элдэв сонин. УБ.
9. Рубрук Г. 1988. Дорно этгээдэд зорчсон минь.
10. Түдэв Л. 1999. Ам цагаан цааса биет, алтан номын үсгэн хэлт. «Монголын уран зохиолын дээжис». LX боть. УБ.
11. Хайсиг В. 1992. Монголын түүх ба соёл. Хөххот.
12. Хүүхэнбаатар Д. 1964. Монгол гүрний элчин харилцаа. УБ.
13. Шагдарсүрэн Ц. 1991. Монголчуудын утга соёлын товчоон. УБ.
14. 1997. XIV-XIX зууны Монголын гадаад харилцаа. УБ.
15. Бичурин Н. Я. 1950. Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древних времена. М.

16. Кара Д. 1972. Книги монгольских кочевников. УБ.

17. Окладников А. П. 1972. Центрально-Азиатский очаг первобытного искусства. Новосибирск.

18. Хун Мэн. 1975. Полное описание монголо-татар. М.

19. Фридрих И. 1979. История письма. М.

### Resume

"Elch" news and its traditional & modernization issues

Throughout this article, I analyzed about since when and how the Mongolian used a method of communicating via a courier, which is one of the first means of information communication.

This article stated that as a mean of hurrying a courier and sharing information had more developed and had gone beyond a simple communication between two parts, it had become a mean of modern emissary' communication of powers and countries and therefore, it had been turned as an understanding of diplomatic custom. Herewith, I endorsed that modern words such as "Elchin said" (ambassador) and "Elchin saidyn yam" (embassy) are originated from "Elch medee" (emissary news).